

олж тогтоох ёстой. Чингэсийн байлдан дагуулалт нь түрэг-монголчуудын тухайд гавъяа, европынхны хувьд тэднийг азаар тойрсон гай юм.

Түрэг, монголчуудад үзэл бодлоо хамгаалж нотлохын хэрэгцээ үгүй ажээ. Учир нь тэдний үзэл бодол бол ухаан үл хүрэх онол биш, зүгээр л хүртэмж, мэдрэмж юм. Их овгийнхоо онгоныг сүслэн хүндэтгэхдээ тэд алтан нарыг алган дээрээ үзэж, зэсэн улаан галын элчийг мэдэрч, цэцгийн анхилуун үнэрт согтоорхох мэт болдог байна. Энэ бол баримт хэрэглэгдэхүүн үл шаардах энгийн үнэн юм. Харин франц, германчуудын монголчуудыг үзэн ядах хорсол огт хоосноос урган гарсан учир тэд түүндээ иш үндэс эрж сурагладаг байжээ. Энэ учираар европынхны онол гэгч гарсан юм. Тодруулбал хоттой хонинд орсон чоно мэт өөрсдийнхөө хядсан «соёлгүй», «хашин хойрго», ази, африкийнхан, индиан полинезчуудад бүслүүлсэн соёл иргэншлийн төв нь их Европ юм гэж тэр онол «нотолдог» бөгөөд «соёлгүйчүүд»-эд Оросыг ч адил хэмжээнд хавсаргажээ.

Европ төвийн тогтолцоот үзэл баримтлалыг оросууд ямар ч нягтлал, шүүмжлэлгүйгээр хүлээж авсан юм. XVI-XVII зууны Оросын Ихс думын түшмэл нар хавчин гадуурхах атгаг санаа өвөрлөөгүйн учир татаар, башкир, халимагийн морьт цэргийг Польш, Шведийн эсрэг зоримог ашигладаг байсан атал XIX зууны гэгээрсэн язгууртнуудын амны уншлага болсон «татаар» гэдэг үгнээс «зэрлэг, догшин», «дураар авирлагчид» гэх утга салахаа больсон билээ. Энд өгүүлэгдэн бүхий асуудалд түүхийн үүднээс шудрагаар хандвал зохилтой гэж үзэж байна.

Орчуулсан **Д. МААМ**

### **ЛЮ ШАОЦИ-ГИЙН «ОНЦГОЙ ХЭРЭГ»**

**Ю. М. Галенович**

Хятадын Коммунист нам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын удирдагчдын нэг, нэрт хувьсгалч Лю Шаоци 1988 оны 11-р сарын 24 нд нас сүүдэр 90 хүрэх байлаа. Хятадын хувьсгалын үйл хэргийн ялалтын төлөв зэвсэгт тэмцэл, нууц ажиллагааны хүнд бэрх жилүүдэд залуучуудын, дараагаар нь үйлдвэрчний эвлэлийн удирдагч байсан Лю Шаоци ХКН-ын удирдлагад голлох байр сууринд дэвшин гарч ирсэн юм. Хятадад ардын хувьсгал ялахад хийгээд БНХАУ байгуулагдаж, түүний социалист үндэс суурь үүсэн тогтох, олон улсын тавцанд Хятадын нэр хүнд өсөн бэхжихэд түүний байгуулсан асар их гавъяаг нийтээр хүлээн зөвшөөрдөг билээ.

Лю Шаоци 1927 онд ХКН-д элссэнээс хойш, намын удирдах дээд байгууллагад тасралтгүй ажилласаар иржээ. Тэрээр 1956 онд ХКН

ын VI их хурлаас Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын хорооны гишүүнээр сонгогдож, ХКН-ын Төв Хорооны орлогч дарга болсон ба 1959 оноос БНХАУ-ын дарга байв, «Соёлын хувьсгалын» гамшигт жилүүдэд Лю Шаоци бусад олон удирдагчдын нэг адил ул үндэсгүй залхаан цээрлүүлтэнд өртөж, төрийн болоод намын бүх албан тушаалаасаа авахуулан, ХКН-ын эгнээнээс хөөгджээ. 1980 оны 3-р сард ХКН-ын V бүгд хурал Лю Шаоциг бүрэн цагаатгах тухай шийдвэр гаргасан байна. Толилуулан бүхий эл өгүүлэлд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Даргын амьдралын сүүлчийн эмгэнэлт үеийн тухай өгүүлэх юм.

1966 он Лю Шаоци-гийн хувьд бүтэмж муутай эхэлжээ. Оны эхээр хүндээр өвчилж, өвчнийхээ айхтар хэцүүг ойлгон, гэрийнхэндээ: «Амьдрах хоног минь цөөн үлдэв бололтой. Энэ богинохон хугацаанд ахиухан зүйл хийх хэрэгтэй байна. Маркс над ахиад нэг арван нас өгдөгсөн бол ч бид хятадыг баян, хүчирхэг улс болгож чадахандаа»<sup>1</sup> гэж хэлж байв.

Тэр үед Лю Шаоци БНХАУ-ын дарга, ХКН-ын Төв Хорооны орлогч даргын хувьд ХКН ба Хятадын төрийн өдөр тутмын ажлыг хэдэн жилийн турш удирдаж байв. Лю Шаоци намын ч, улс орны хэмжээнд ч, нийтээр хүлээн зөвшөөрсөн «хоёрдугаар хүн» байснаар үл барам, 60-аад оны дунд үеэр жинхэнэ удирдагчийн байр сууринд гарч эхэлсэн ба намын гишүүд, ард түмний дунд нэр хүндээрээ ч, гарт нь төвлөрсөн засгийн эрх мэдлийн хувиар ч Мао Зэдунгээс дутуугүй байв.

Лю Шаоциг БНХАУ-ын даргаар дахин сонгогдсонтой холбогдуулан 1965 оны 1-р сарын 3-ны орой Бээжинд аяндаа болсон олон нийтийн сүрт жагсаалыг би сайн санаж байна. «Их үсрэлтийн» бодлого гутамшигтайгаар балран унасаны дараа, улс ардын аж ахуйд бий болсон хямралт байдлыг арилгах талаар 60-аад оны эхээр амь хайргүй зүтгэснийг нь талархаж буйн тэмдэг болгон Лю Шаоцигийн хөргийг энд тэндгүй барьсан хүмүүсийн цуваа хотын төв гудамжаар дүүрсэн байлаа. Тэгэхэд Лю Шаоци: «БНХАУ-ын сүйрлийн ирмэгт байгаагийн 70% нь хүмүүсийн буруу, 30% нь цаг бусын гай юм»<sup>2</sup> гэж мэдэгдэж байв. БНХАУ-ын Даргын санаачилгаар боловсруулсан улс ардын аж ахуйг бүх талаар зохицуулах, бэхжүүлэх чиг шугамыг хэрэгжүүлсэний үрээр «их үсрэлтийн» уршигийг амжилттай гэтлэн давсан юм.

Хятадын шинэчлэлд шаардагдах бааз бий болгоход хүчээ төвлөрүүлэх зорилго бүхий III 5 жилийн анхны он нь 1966 он болох ёстой байв.<sup>3</sup> Гэвч 1965 оны 1-р сард ревизионизмийн эсрэг чиглэсэн юм хэмээн хийхээр завдан буй «соёлын хувьсгалын» мөрийн хөтөлбөрийг Улс төрийн товчооны хуралдаан дээр Мао Зэдун танилцуулсан юм. Тэрхүү мөрийн хөтөлбөрийн эхний зүйл нь «засгийн эрхэнд байгаа болон капиталист замаар замнагч этгээдүүдийг албан тушаалаас нь зайлуулах шаардлага байв. Маотай ярьсан яриагаа иш татан, Америкийн сэтгүүлч Э. Сноугийн гэрчилж байгаагаар, Лю Шаоци Улс төрийн товчооны тэр хуралдаан дээр Маогийн үзэл санааны эсрэг үг хэлж, үүнийхээ улмаас зайлах хэрэгтэй боллоо гэж шийджээ.<sup>4</sup>

Жилийн дараа Мао Зэдун «соёлын хувьсгал хийх» санаагаа хэрэгжүүлж эхлэв. Тэрээр энэ кампаний эхний хэдэн сарын турш Лю Шаоциг өөртөө татах, тэр ч байтугай ашиглах гэж оролдсон бөгөөд

Лю Шаоци нам, ард түмэн болоод өөрт нь учирч буй аюул заналыг илтэд дутуу үнэлсэн юм. Мао Зэдун эрс шийдэмгий хөдлөхөөр завдаж байв. Тэрээр 1966 оны 7-р сарын 24-нд Улс төрийн товчооны өргөтгөсөн хуралдааныг зарлан хуралдуулж, Лю Шаоциг шүүмжлэн эрсдүүлжээ.<sup>5</sup> Мөн оны 8-р сард болсон ХКН-ын Төв Хорооны VI дахь удаагийн XI бүгд хуралдаан дээр Мао Зэдун ХКН-ын дотор Лю Шаоци тэргүүтэй «хөрөнгөтний штаб» байгааг шууд сануулан дурьдаж, энэ «штаб» руу «гал нээхийг» уриалсан том үсгийн сонинг бүгд хуралд оролцогчдод танилцуулжээ. Бүгд хурлаар Төв Хорооны удирдлагад өөрчлөлт хийж, Лю Шаоциг удирдлагад эзлэх байр сууриар нь 8-р байранд ухраажээ. Лю Шаоциг ихэд хүндэтгэн, түүнийг амьдралынхаа сүүлчийн мөч хүртэл багшаа гэж тооцож байсан ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн Чэнь И дээрх бүгд хурлаар Лю Шаоциг зайлуулсан нөхцөл байдлыг хэмжээгүй эрхт байдал, хаант засгийн ёс-ны илрэл гэж тодорхойлжээ. Энэхүү шийдвэрийн уршгаар Лю Шаоциг ажил хэргээс холдуулсан юм. Лю Шаоци хуть заяаныхаа эцсийн шийдвэрийг хүлээж байлаа,

Хэрвээ намын гишүүн хүн улс төрийн шинжтэй алдаа хийсэн гэж сэжиглэгдэх буюу түүний намтар тодорхой бус гэсэн асуудал гарвал, тэр хүн хэдийгээр ёс төдий албан тушаалдаа байх боловч жинхэнэ ажил хэргээс хөндийрдэг нь «соёлын хувьсгалын» практик болж байв. Ийм байдалд хүн удаан хугацаагаар заримдаа, хэдэн жилээр ч байдаг байв. Түүнээс өөрийнхөө үйл явдал, үзэл бодолд «Өөрийн шүүмжлэлтэй» дүн шинжилгээ хийх, «тайлбар» гаргахыг шаардана. Ажил хэргээс хөндийрүүлэн хатуу хяналтанд байлгахдаа, түүний эрх чөлөөг ихэд хязгаарладаг байв. Хохирч хэлмэгдсэн намын гишүүнээс нууцгайгаар, түүний нэр хүндийг гутаах материал цуглуулан, түүний «алдаа» буюу гэмт хэргийг шүүх олон нийтийн кампанийг өдөөн тухирдаг байв. Тийм намын гишүүн чухамдаа үг хэлэх эрхээ хасуулж, зөвхөн дээд шатны байгууллага буюу «олон түмний» асуултанд л хариулах үүрэгтэй аж. Ийм байдалд орсон олон коммунистууд, тэвчиж үл чадан, амиа хорлосон юм.

Маогийн «үндсэндээ сайн болж» гэж тогтоолд тэмдэглэсэн тийм «өөртөө хийсэн дүн шинжилгээ»-г Лю Шаоци арга буюу бичих болсон юм. Эрх чөлөөгөө хасуулсан тэр мөчийг хүртэл Маогийн тогтоолыг Лю Шаоци хадгалсан гэж ярьдаг. Лю Шаоциг «шүүмжлэх» кампанийг 1966 оны 12-р сард хот хөдөөгүй өрнүүлжээ. Ингэхдээ энэ кампанийг зохион байгуулагчид Лю Шаоцид өөрт нь болон түүний «улс төрийн алдаатай чиг шугамын» талаар арга хэмжээ авахыг олон түмэн өөрсдөө Төв Хорооноос шаардаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхийг оролдсон юм. «Соёлын хувьсгалыг» зохион байгуулагчид түүний үзэл бодол, үйл ажиллагааны талаар мушгин гуйвуулсан ойлголтыг санаатайгаар бий болгосонд Лю Шаоци маш их санаа зовниж байв. Гэвч өөрийгөө хамгаалж ядахдаа ганц ч болов үг олны өмнө хэлэх бололцоо түүнд байсангүй. «Ард түмэн намайг алдаа хийсэн гэж ойлгох вий гэхээс бүхнээс илүү эмзэглэж байна<sup>9</sup> гэж төрөл төрөгсөддөө тэрээр халаглан өгүүлж байжээ.

Хавчин хяхах энэхүү кампанийг зогсоох гэсэндээ Лю Шаоци 1966 оны 12-р сарын эцсээр, БНХАУ-ын даргын албан тушаалаасаа огцрох оролдлого хийсэн юм. Энэ тухайгаа Жоу Энълайд хэлэхэд нь Жоу

Эньлай: «тэгээд нэмэргүй, энэ бол БХАТХ-ын онцгой эрхийн асуудал»<sup>10</sup> гэж хариулжээ. Тэгэхээр нь Мао Зэдунтэй биечлэн уулзахыг Лю Шаоци шаардсан бөгөөд энэ уулзалт 1967 оны 1-р сарын 13-ны шөнө болжээ. ХКН-ын дээд хоёр удирдагчийн хоёр биентэйгээ уулзсан сүүлчийн шийдвэрлэх уулзалт болов. Тэд өөрсдийн нэртэй холбоотой улс төрийн мөрийн хөтөлбөрийг тэргүүлж байсан ба намын доторхи янз бүрийн хүчний тэмцлийг тусган хурц ширүүн, эвлэршгүй сөргөлдсөн юм. Юуны өмнө «өөрт нь оногдож буй» шугамын тухай асуудлаар» алдсаны гэм бурууг мөн «өргөн олон кадр ажилтанд тохсон ял зэмийг аль болох түргэхэн арилгахын тулд, гол хариуцлагыг үүрэхэд бэлэн байна» гэж Лю Шаоци мэдэгдсэн нь энэ уулзалтаас тодорхой болжээ. «Соёлын хувьсгалыг даруйхан дуусгахын» тулд Лю Шаоци БНХАУ-ын дарга, ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүн, «Мао Зедуны сонгомол зохиолыг» Хэвлэх комиссын даргаасаа огцорч, Яньанд очиж амьдрахад бэлэн байгаагаа илэрхийлсэн байна. Мао Лю Шаоцитэй салах ёс хийж «сайн дураараа, эрүүл мэндээ бодно биз»<sup>11</sup> гэж хэлээд үдэн гаргажээ.

Ийнхүү Лю Шаоци буулт хийсэн юм. Мао Зэдун түүнийг хэрэгсэж үзсэнгүй. Эхлээд харахад, Лю Шаоци ялагдан, дэвшүүлсэн саналаа хэрэгжүүлж чадаагүй байна. Гэвч мөн чанартаа ярилцагч хоёр аль аль нь уламжлалт аргаар харилцан зөрөлдөн тэмцжээ. Хятадын улс төрийн уламжлалын дагуу тэдний хэн нь ч маргаантай асуудлын тухай, давын өмнө соёлын хувьсгалтай холбоотой асуудлаар шуудхан ярилцсангүй.

Мао тэргүүн удирдагчийн байр сууриндаа үлдэхийг дээр гэж бодсон юм. Түүний бодлоор бол, Лю Шаоци хожигдон, улс төрийн их тоглоомоос хасагдсан бөгөөд Маогийн дур зоргоор, өөрт нь хүлцэнгүй номхон захирагдах явдал л Лю Шаоцид үлдсэн аж. Лю Шаоци асар их төлөв байдал гаргаж, ноцтой буулт хийхдээ (БНХАУ-ын дарга, ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын хорооны гишүүнээс огцрох, мөн Мао Зедуны улс төрийн үзэл бодолтой эвлэрэх) Мао Зедуныг «соёлын хувьсгалын» цар хүрээг арга буюу багасгахад хүргэх, улмаар намын удирдах ажилтныг өргөн хүрээтэй цэвэрлэх гэж бодсоныг нь тасалдуулах гэсэн юм. Үүнийг нь Мао Зэдун зөвшөөрсөн бол намын удирдлага дахь хүчний харьцаа түүний хувьд ашиггүй болж, намын кадр ажилтнууд өөрсдийнх нь албан тушаалыг хамгаалсаны төлөө Лю Шаоцигийн ачийг санахсан билээ. Ингэвэл Мао Зэдунд ёс төдий ялалт болох байсан боловч, хэрэг дээрээ тийм болсонгүй.

Мао Зэдунтай уулзаж ярилцсанаас хойш Лю Шаоци, түүний гэр бүлийнхэн ганц ч өдөр амар тайван амьдарч чадаагүй юм. ХКН-ын Төв Хорооны Жуннаньхайн ордны үйлчлэх ажилтнуудаас бүрдсэн «самуун дэгдээгчид» Лю Шаоцигийн гэр бүлээрээ амьдарч байсан байранд дайран орж, том үсгийн сонин наан, «шүүмжлэн тэмцэх» цуглаан хийжээ. «Самуун дэгдээгчдийн» өөрт нь оноосон бүх бурууг Лю Шаоци няцааж, «Хэзээ ч Мао Зедуны үзэл санааны эсрэг байгаагүй, хэзээ ч дарга Маогийн эсрэг үг хэлээгүй, харин өдөр тутмын ажлын талаар үзэл бодол зөрж байсан гэж мэдэгдсэн байв.

1967 оны 5-р сард Лю Шаоцийн «онцгой хэргийг» шалгах групп байгуулагдаж, түүнийг Зян Цин толгойлжээ. Группийн бүрэлдэхүүнд ХКН-ын Төв Хорооны канцелярийн дарга Кан Шэн, намын удирдагчдыг хамгаалах асуудал эрхэлж байсан Ван Дунсин, мөн тэр үед Лю Шаоцигийн эхнэр Ван Гуанмэйн гэмт хэргийг мөрдөх группыг толгойлж байсан Нийгмийг Аюулаас хамгаалах Яамны сайд Се Фужи нар байв. Лю Шаоци түүний эхнэр хоёул тусгай албаныханы гарт орсон бөгөөд гэмт хэргийн нотолгоо гаргахаас ч бүр өмнө, шийтгэлийн дээд хэмжээ оногдуулсан гэмт хэрэгтэн мэтээр тэдэнд хандаж байв,

Эх орноосоо урвасан, намын эсрэг үйл ажиллагаа явуулсан гэж буруутгаж буй намын гишүүдийг онцгой хэрэгтэн гэж үздэг журам ХКН-д байсаныг хэлэх хэрэгтэй, Онцгой хэргийг мөрдөн шалгах группынхэн «соёлын хувьсгал» эхэлмэгц ХКН-ын Төв Хорооны зохион байгуулалтын мэдлээс гарч, ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны орлогч гишүүн, удалгүй УТТ-ны гишүүн, ХКН-ын Төв Хорооны орлогч дарга болж Намын дээд удирдлагад гарч ирсэн Кан Шэний шууд мэдэлд захирагдах болсон юм.

«Онцгой хэргийг» эрхлэн явуулах тухай шийдвэрийг батлан гаргахад Кэн Шэний оролцоотойгоор Мао Зэдун биечлэн хөөцөлдсөн юм. Мөрдөн мөшгилтийг намын шугамаар явуулж, байгууллага хамт олны зөвшөөрөлгүй хэрэгжүүлжээ. Шийдвэрийг намын дээд удирдлагын явцуу бүлгийнхэн гаргасан юм.<sup>12</sup> Лю Шаоцигийн хэргээр зөвхөн Бээжинд л гэхэд 64 хүнийг баривчилжээ. Түүний эхнэр Ван Гуанмэй 11 жил хагас шоронд хоригдож, гурван хүү нь шоронд орж, хоёр нь тэндээ нас барж гурван охин нь мөн л ганцаарчилсан байр гэгчид хоригдох зэрэг янз бүрээр «дахин хүмүүжигджээ».<sup>13</sup>

Ван Гуанмэйн «Онцгой хэргийг эрхлэх группийнхэн түүнийг америкийн тагнуул гэж ч нотолж байлаа. БНХАУ-ын дарга «Алс Дорнод дахь АНУ-ын тагнуулын удирдагч»<sup>14</sup> байсан мэт хуурмаг мэдээ тараахыг Зян Цин оролдож байв.

1967 оны зун Лю Шаоцигийн эсрэг тэмцлийн» шинэ долгион бүх Хятад орноор тарахад Лю Шаоцигийн гэр бүлийнхэн түүнийг БНХАУ-ын даргын албан тушаалаас огцруулах асуудлыг дахин тавихыг оролдсон боловч бүтэлтэй болоогүй билээ.

Төгсгөл ойртож буйг ойлгон, Лю Шаоци 1967 оны 7-р сард өөртөө байнга хадгалж байсан «хамгаалах жуух» болох хоёр баримт бичгийг хүүхдүүддээ танилцуулжээ. Эдгээр нь «соёлын хувьсгалын» эхний шатан дахь Лю Шаоцигийн үйл ажиллагааг мөн Ван Гуанмэйн тосгонд явуулсан ажлыг Мао Зэдун дэмжиж байсныг батлаж байгаа аж. Гэвч энэ нь тус болсонгүй. 1967 оны 7-р сарын 18-нд ээлжит шүүн хэлэлцэх хурлын дараа Лю Шаоциг гэр бүлээс нь тусгаарлаж, амины сууцны нь нэг өрөөнд хорионд суулгажээ. Ван Гуанмэй тэр байрны нөгөө хэсэгт, хүүхдүүдийг мөн эцэг, эхээс нь тусдаа байлгажээ. Лю Шаоци түүний гэрийнхэний явж гарах эрх чөлөөг хасч, гэрт нь нэгжлэг хийсэн байна.<sup>16</sup>

Айхтар доромжилон, тамлан зовоодог байсан шүүн хэлэлцэх цуглаан дараа дараагаар болж байв. Настай болсон хийгээд зай завсаргүй байцаалтаас тамирдан туйлдсан Лю Шаоциг хүмүүс гар зангидан цохиж, өшиглөж, үснээс нь үхтээн зулгааж, хүнд хэцүү бай-

далд удтал байлгаж,... зургийг нь авч байв. Түүнийг гутаан доромжилсон гэрэл зургийг «соёлын хувьсгалын» удирдах бүрэлдэхүүнд тарааж байв.<sup>17</sup>

1967 оны 8-р сарын 5-нд Лю Шаоци сүүлчийн удаа эхнэртэйгээ уулзжээ. Тэр өдрийн орой Лю Шаоци Үндсэн хуулийг дагаж мөрдөхийг шаардсан эсэргүүцлээ хэлж бичүүлжээ. Үүнийхээ хариуг тэр аваагүй юм.<sup>18</sup> Дараа нь Лю Шаоци Мао Зэдунд өөрийг нь нам, социализмын эсрэг тэмцэж байгаа мэт буруутгаж буйг шийдвэртэй эсэргүүцсэн захидал бичиж, БНХАУ-ын даргын албан тушаалаас огцрох тухайгаа дахин мэдүүлж, эрх чөлөөгөө хасуулаад удаж буйгаа<sup>19</sup> дурьджээ. Гэвч үүндээ ч бас хариу авсангүй. Гэхдээ тэр үед хэлмэгдүүлэх механизм тасралтгүй ажиллаж байв.

1967 оны 9-р сарын 13-нд Ван Гуанмэй албан ёсоор баривчлагдаж, шоронд хоригджээ.<sup>20</sup> Хэдэн өдрийн дараа Лю Шаоци харгалзагчаар дамжуулан «надаас ч эхээсээ ч холхон байгаарай»<sup>21</sup> гэж хүүхдүүддээ хэлүүлжээ. Энэ бол хүүхдүүдэд нь хүрсэн түүний сүүлчийн үг байлаа. Хүүхдүүд нь доромжлолыг тэвчин өнгөрөөхөд хүнд болохыг тэрээр маш сайн ойлгож, мөн тэднийг залхаан цээрлүүлт хүлээж буйг ч мэдэж байсан учир тэднийхээ хувь заяаг хүндрүүлэхгүйг бодсон хэрэг байжээ.

Бидэнд мэдэгдэж буй мэдээ баримтаар, Лю Шаоци 1968 оны зун дөнгөж бие даан хөдөлж байжээ. Удалгүй тэр бүр явж чадахаа больжээ. Түүний эмийг ч хассан байна. «Соёлын хувьсгалын амьд бай» болгох зорилгоор түүнийг хараахан алаагүй байсан бололтой.

1968 оны 10-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны XII бүгд хурлаас Лю Шаоциг намаас хөөх шийдвэр гаргав. Энэ шийдвэрийн тухай өөрт нь түүний 70 насны ойн өдөр 1968 оны 11-р сарын 24-нд дуулгажээ.

Одоо Хятадад энэ үйл явдлыг ийн үнэлж байна. Үүнд: «ХКН-ын Төв Хорооны XII бүгд хурал намын дотоод амьдралын хамгийн хэвийн бус нөхцөлд Зян Цин, Кан Шэн, Се Фужи болон бусад хүмүүсийн хуурамч өчгийн үндсэн дээр зохиосон «тэрслүү, өдөөн тагнагч, тэмцлээс урвагч Лю Шаоцигийн гэмт хэргийг мөрдөн байцаах тухай илтгэлд» Лю Шаоциг намаас «үүрд хөөх», түүнийг «намын болон бусад бүх албан тушаалаас» халах алдаатай шийдвэр баталсан юм. Бүрэн алдаатай энэхүү улс төрийн дүгнэлт ба зохион байгуулалтын арга хэмжээ нь Лю Шаоциг хүний нь хувьд цочирдуулсан төдийгүй намын олон мянган гишүүд, кадр ажилтан, олон түмний төлөөлөгчид, сэхээтнүүдийг хөнджээ. Ингэж манай намын түүхэнд хамгийн тутамшигт хэрэг гарч, улс төр, зохион байгуулалт, үзэл суртлын талаар урьд өмнө үзэгдээгүй үймээн бий болсон юм»<sup>22</sup> гэжээ.

Лю Шаоцигийн «хэргийн» төгсгөл дараах байдлаар дуусчээ. 1969 оны 10-р сарын 1-нд, хэдийгээр Лю Шаоциг эмч хэзээ ч үхэж магадгүй нь гэж урьдчилан сануулж байсан боловч, түүнийг үхлийн өмнөх байдалд байхад Бээжингээс Кайфэн хотод авчирах ажлыг Ван Дунсин биечлэн эрхэлжээ.<sup>23</sup> Лю Шаоциг дамнуургаар онгоцонд хүргэжээ. Кайфэнд түүнийг цахилгаан хүчдэлтэй өргөст тор бүхий өндөр ханаар хүрээлэгдсэн тусгай шоронд хорьжээ. Шоронд байхдаа түүний уушиг үрэвсэж эхэлсэн боловч эмнэлэгт аваачих зөвшөөрөл ол-

доогүй байна. Ингээд 1969 оны 11-р сарын 12-нд Лю Шаоци нас баржээ. Халдварт тахал өвчнөөр үхсэн тул шарилыг шатаасан гэж хүүр шатаах газрын бүртгэлд тэмдэглэжээ. Чандартай бумбан дээр нь Лю Вэйхуан гэсэн зохиомол нэр бичсэн байв.

Лю Шаоцигийн хувь заяаны талаар төрөл төрөгсөд нь дөнгөж 1972 онд мэджээ. Түүний «онцгой хэргийг» мөрдөх группийн дарга Лю Шаоцигийн хүүхдүүдээс Мао Зэдунд илгээсэн захидлын хариу болгож, «Эцэг чинь үхсэн. Эхтэйгээ уулзах болно»<sup>24</sup> хэмээн Маогийн гаргасан тогтоолын агуулгыг тэдэнд дамжуулжээ. Гэхдээ Лю Шаоцигийн чандрыг төрөл төрөгсөдөд нь өгч чадахгүй, энэ талаар гадны хүмүүст ярихыг хориглосон гэж хүүхдүүдэд нь дуулгажээ. Харин Лю Шаогийн хувь заяа хэрхсэнийг мэдэхгүй» гэж тайлбарласан байна. Лю Шаоцигийн эхнэр Ван Гуанмэй дөнгөж 1979 оны хавар шоронгоос суллагдажээ.

1980 оны 3-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны XI удаагийн V бүгд хурал Лю Шаоциг цагаатгах тухай шийдвэр гаргаж, түүнд оноосон бүх гэм бурууг хүчингүй болгож, түүнийг «агуу их марксист», «пролетарийн хувьсгалч» гэж нэрлэжээ. 1980 оны 5-р сарын 17-нд түүний дурсгалд зориулсан гашуудлын цуглаан Бээжинд болов. Тэр цуглаан дээр Дэн Сяопин хэлсэн үгэндээ: «Лю Шаоци бол пролетарийн агуу их хувьсгалч, бүх нам, нийт улс орны хайр талархлыг хүлээсэн нам, төрийн шалгарсан гарамгай удирдагч байлаа» гэжээ.

Лю Шаоциг мөрдөн хавчиж, үйлий нь үзэх ажлыг зохион байгуулагчдаас олон хүн хожим хойно намын хийгээд эрүүгийн зэмлэл шийтгэл хүлээжээ.

1. 1966 — 1976 оны баримтыг түүх эрэгцүүлж байна. Бээжин 1986. 1-р боть, 19-р тал (хятад хэл дээр)
2. «Хунци» сэтгүүл 1967. № 13 11-р тал
3. 1966—1976 оны баримтыг... 1-р боть 19-р тал
5. 1966-1976 оны баримтыг... 1-р боть, 5-р тал
6. «Гунжэнь жибао» сонин 1980. XII, 5, 6, 8,
7. 1966—1976 оны баримтыг ... 1-р боть, 183-р тал
8. «Гунжэнь жибао» сонин 1980. XII, 5, 6, 8
9. 1966—1976 оны баримтыг ... 1-р боть, 11-р тал
10. «Гунжэнь жибао» сонин. 1980. XII, 5, 6, 8
11. Мөн тэнд
12. 1966—1976 оны баримтыг ... 1-р боть 1-р тал
13. Мөн тэнд 41-р тал ,
14. Мөн тэнд 2-р боть. 92—93-р тал
15. Мөн тэнд 1-р боть, 27-р тал
16. Мөн тэнд
17. Мөн тэнд
18. Мөн тэнд 30—31-р тал
19. Мөн тэнд: 31-р тал
20. Мөн тэнд 32-р тал
21. Мөн тэнд
22. ХКН-ын түүхийн лекц. Тяньзинь 1983. 365-р тал (хятад хэл дээр)
23. 1966—1976 оны баримтыг ... 1-р боть, 45-р тал
24. Мөн тэнд 36-р тал
25. Мөн тэнд

**«Проблемы Дальнего Востока»  
(1988 оны № 6) сэтгүүлээс  
орчуулсан Л. Бэгзжав  
1988. 3. 13.**